



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 4/275

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх "Жаст ойл шатахуун түгээх станцын авто замын уулзварын гэрлэн дохио, босоо тэмдэг суурилуулах ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Өлзийжаргал - УБХ-ийн дарга

Гишүүд:
Ц.Бямбацогт - Иргэний төлөөлөл
Ш.Бямба - Сайнцагаан сумын ЗДТГ мэргэжилтэн
Б.Батмөнх - Аймгийн Нисэх буудлын дарга
Нарийн бичгийн дарга: С.Ууганбаяр - ОНӨГ-ын дарга

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Өлзийжаргал)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (С.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200739